

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

Гар бичмэлийн эрхтэй ©

ЗӨВӨӨ ДЭЛГЭРМАА

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ӨМӨНГИЙН УРЬДАЛ ЭМГЭГ ТҮҮНД
НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ТАРХАЛТЫГ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДУНД СУДАЛСАН
СУДАЛГАА

Е 720100 Нийгмийн эрүүл мэнд

Нийгмийн Эрүүл Мэндийн магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл

Улаанбаатар хот
2013 он

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ,
ЭРҮҮЛ МЭНДИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ИХ СУРГУУЛЬ

ЗӨВӨӨ ДЭЛГЭРМАА

УМАЙН ХҮЗҮҮНИЙ ӨМӨНГИЙН УРЬДАЛ ЭМГЭГ ТҮҮНД
НӨЛӨӨЛӨХ ЗАРИМ ЭРСДЭЛТ ХҮЧИН ЗҮЙЛИЙН ТАРХАЛТЫГ
БАГАНУУР ДҮҮРГИЙН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ДУНД СУДАЛСАН
СУДАЛГАА

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

Анагаах ухааны доктор, профессор Д. Авирмэд

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

Анагаах ухааны доктор Д. Оюунчимэг

Улаанбаатар хот
2013 он

ХУРААНГУЙ

Умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэг түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг Багануур дүүргийн эмэгтэйчүүдийн дунд судалсан судалгаа

Үндэслэл:

Өвчлөлийн олон улсын статистик мэдээгээр эмэгтэйчүүдэд тохиолдох хавдрын дотор умайн хүзүүний өмөн(УХӨ) тохиолдлын тоогоороо хоёрдугаар байр эзэлдэг бөгөөд манай оронд умайн хүзүүний өмөнгийн өвчлөл эмэгтэйчүүдийн дунд тохиолдож байгаа хорт хавдрын дотор хоёрдугаарт орж байна. Умайн хүзүүний өмөнгийн нийт тохиолдлын 85% нь хөгжиж буй оронд тохиолддог байна. (37,ДЭМБ-2010) Олон улсын хавдрын бүртгэлийн төвийн мэдээлэлээр дэлхийд умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн түвшин 100000 эмэгтэйд 15.5 гэжээ.

Манай оронд 2000 оны өвчлөл, нас баралтыг 2008 онтой харьцуулахад умайн хүзүүний хорт хавдрын өвчлөлийн түвшин 6.6 байснаа 2 дахин буюу 15.5, нас баралтын түвшин 3.02 -аас 4.0 болж нэмэгджээ.

Харин Багануур дүүргийн хэмжээнд умайн хүзүүний өмөнгийн өвчлөл 2008 онд 5.4, 2009 онд 7.7, 2010 онд 5.4, 2011 онд 9.3 болж тус тус нэмэгдсэн байна. Монгол улсад 100000 эмэгтэйд 26.6 буюу умайн хүзүүний өмөнгийн өвчлөлийн түвшин харьцуулсан улс орнуудаасаа өндөр байна. Гэтэл манай оронд аймаг, дүүргүүдийн түвшинд умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэг, түүнийг үүсгэж буй зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтын талаар хийгдсэн судалгаа байхгүй байгаа нь энэ судалгааны ажил хийх үндэслэл болсон юм.

Зорилго:

Багануур дүүргийн эмэгтэйчүүдэд умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэг, түүнд нөлөөлөх зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судлах.

Зорилт:

1. Багануур дүүрэгт оршин суудаг 25-60 насны эмэгтэйчүүдийг умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгийг илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулах
2. Умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгийн тархалтыг тогтоох

3. УХӨ-ийн урьдал эмгэгийг үүсгэх зарим эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг Багануур дүүргийн түвшинд тогтоох

Судалгааны арга аргачилал:

Судалгааг нэг агшингийн судалгааны загвараар дүүргийн таван хорооны 25-60 насны нийт эмэгтэйчүүдээс санамсаргүй түүвэрлэлтийн аргаар 410 эмэгтэйг сонгон асуумж авч, хавдар илрүүлэх эмэгтэйчүүдийн үзлэг, цууны хүчлийн сорил, эсийн шинжилгээ хийн судалгааг 4 үе шаттайгаар 9 үзүүлэлтээр умайн хүзүүний өмөн, түүний урьдал эмгэгийг үүсгэх эрсдэлт хүчин зүйлийн тархалтыг судласан.

Үр дүн:

Нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 4.1%-тамхи татдаг, 4.8%- эрт насанд төрсөн, 19.6%-олон удаа төрсөн, 16.8%-олон удаа үр хөндүүлсэн, 1.5%-бэлгийн харьцаанд эрт орсон, 6.9%-жирэмслэлтээс сэргийлэх дааврын бэлдмэл хэрэглэдэг, 29.8%-БЗХӨ илэрсэн, 18.1%- бэлгийн олон хамтрагчтай эмэгтэйчүүд, 75.6% -эсийн шинжилгээ тогтмол хийлгэдэггүй эмэгтэйчүүд байна. ЭХЗ-үүдийн 1 хүчин зүйлийн регресс шинжилгээг хийхэд БЗХӨ нь УХӨ-ийн урьдал эмгэг үүсэхэд эрсдэл болж байгаа төдийгүй БЗХӨ-өөр өвдөхөд эрсдэл нь 2.1 дахин нэмэгдэж байна.

Судалгаанд хамрагдсан нийт 410 эмэгтэйг УХӨ, урьдал эмгэг илрүүлэх скрининг үзлэгт хамруулсанаас умайн хүзүүний урьдал эмгэг 98 эмэгтэйд буюу нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 23,9%-д нь илэрсэн байна. 30-39, 40-49, 50-60 насны эмэгтэйчүүдийн дунд умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгийн тархалт ойролцоо 29.5%-30.6% байлаа. Умайн хүзүүний өмөнгийн урьдал өвчинтэй эмэгтэйчүүдийн дундаж нас-42.5, SD-8.92 байна. Үзлэгээр илэрсэн умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгийн хэлбэрүүдийг судлан үзэхэд хөнгөн хэлбэрийн гаж хувирал-75 тохиолдол буюу 76.5%, дунд зэргийн гаж хувирал-22 тохиолдол буюу 22.4%, хүнд хэлбэрийн гаж хувирал 1 тохиолдол буюу 1.0% тус тус илрэв. Бүрхүүл эдийн гаж хувирлын хөнгөн хэлбэр 25-29 насны эмэгтэйчүүдэд 9 илэрч байхад дунд болон хүнд хэлбэрийн гаж хувирал илрээгүй юм. Харин 30-39, 40-49, 50-60 насны эмэгтэйчүүдэд хөнгөн болон дунд хэлбэрийн гаж хувиралын тархалт ойролцоо байгаа бол 50-60 насанд хүнд хэлбэрийн гаж хувирал илэрлээ.

Дүгнэлт:

1. Эмэгтэйчүүдийг скрининг үзлэгт хамруулсаны дүнд умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэг судалгаанд хамрагдсан нийт эмэгтэйчүүдийн дунд 23.9% илэрсэн. Умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгтэй эмэгтэйчүүдийн дундаж нас 42.5,SD-8.92 байна.
2. 30 хүртэлхи насны эмэгтэйчүүдэд үрэвслийн процес давамгайлсан хөнгөн хэлбэрийн гаж хувирал 12%(9), 30-аас дээш насны эмэгтэйчүүдэд дунд хэлбэрийн гаж хувирал насны бүлгүүдэд оройолцоо тархалттай 32%, 50-60 насанд хүнд хэлбэрийн гаж хувирал 1 тохиолдол тустус оношлогдлоо.
3. Умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгт нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлүүдийн тархалт умайн хүзүүний өмөнгийн урьдал эмгэгтэй эмэгтэйчүүдэд эрүүл эмэгтэйчүүдээс 1.1-16.4%-иар илүү тохиолдож байна. УХӨ-ийн ЭХЗ-үүдээс БЗХӨ нь урьдал эмгэг үүсэх эрсдлийг 2.1 дахин нэмэгдүүлж байна. (Нийт судалгаанд хамрагдсан эмэгтэйчүүдийн 4.1%-тамхи татдаг, 4.8%- эрт насанд төрсөн, 19.6%-олон удаа төрсөн, 16.8%-олон удаа үр хөндүүлсэн, 1.5%-бэлгийн харьцаанд эрт орсон, 6.9%-жирэмслэлтээс сэргийлэх дааврын бэлдмэл хэрэглэдэг, 29.8%-БЗХӨ илэрсэн, 18.1%- бэлгийн олон хамтрагчтай эмэгтэйчүүд, 75.6% -эсийн шинжилгээ тогтмол хийлгэдэггүй эмэгтэйчүүд байна.)

Түлхүүр үг:

Умайн хүзүүний өмөн, тархалт, урьдал эмгэг, эрсдэлт хүчин зүйл, үр хөндөлт, жирэмслэлт

ABSTRACT

Study to determine the prevalence of cervical precancer and its some risk factors in women in Baganuur district

Background:

In 2008 the WHO reported, that the cervical cancer is the third most common cancer in worldwide, whereas in our country it's in the ranking place. According to worldwide cancer statistics approximately 85% of cervical cancers occur in developing countries (37 WHO-2010). Also, the International Association of Cancer Registries reported that, the prevalence of cervical cancer was 15.5 per 100000 women. The morbidity was 6.6 in 2000 and it reached to 15.5 in 2008. Unfortunately the prevalence of mortality due to cervical cancer was 3.02 in 2000, and reached to 4.0 in 2008. The occurrence of cervical cancer in Baganuur district is increasing year by year, whereas it was 5.4 in 2008, 7.7 in 2009, 5.4 in 2010 and increased up to 9.3 in 2011. In Mongolia, the prevalence of cervical cancer is registered 26.6 per 100000 women which were higher by comparing with other countries. In recent times the research on prevalence and risk factors of cervical cancer in our country's province and district level implemented rare, so our research work would be the one of basic studies.

Purpose: Study to determine the prevalence of some risk factors for cervical precancer in women in Baganuur district

Objectives:

1. To cover women for cervical precancer screening
2. To determine the prevalence of cervical precancer
3. To determine the prevalence of some risk factors of cervical precancer

Research methodology: The cross sectional study was done. We randomly selected 410 women, aged 25-60, from 5 khoroos of Baganuur district. We prepared the standard questionnaire to identify risk factors of cervical cancer. All women observed by gynecologist and gave some laboratory tests.

Results: Out of 410 women the 4.1 percent were smokers, the 21.2 percent gave early birth, the 19.6 percent had multiple deliveries, the 16.8 percent had multiple intentional abortions, the 1.7 percent had early sexual intercourse, the 15.6 percent took oral contraceptives, the 29.8 percent was detected with STDs, the 15.6 percent had many sexual partners, and the 75.6 percent did not screened by using Pap smear test permanently.

We determined that the 98 women have precancerous diseases out of 410 participants. The prevalence of precancerous disease was higher among the women aged 30-39, 40-49, and 50-60 (29.5-30.6 percent). The average age of women with precancerous disease was 42.5 9 (SD-8.92).

While studying subtypes of precancerous disease we observed that, the incidence rate of mild metaplasia was 75 (76.5 percent), the moderate type 22 (22.4 percent), and the severe type was 1 (1.0 percent). Therefore, 9 cases of mild and moderate types detected among 25-29 age group women. There was no difference between 30-39, 40-49, and 50-60 age group women. Only the one incidence of severe type of metaplasia was detected in women aged 50-60.

Conclusion:

1. Approximately 23.9 percent were detected with a precancerous lesion. The average age of women with precancerous lesions was 42.5 (SD-8.92).
2. The 9 incidences of mild type and 8 cases of moderate type of precancerous disease were detected among women aged up to 30; and the one severe type was determined among women aged 50-60.
3. The 4.1 percent were smokers, the 21.2 percent gave early birth, the 19.6 percent had multiple deliveries, the 16.8 percent had multiple intentional abortions, the 1.7 percent had early sexual intercourse, the 15.6 percent had oral contraceptives, the 29.8 percent was detected with STDs, and the 15.6 percent had many sexual partners.

Among the women detected with precancerous lesions each of prevalence of risk factors occurs 1.1-16.4 percent times more than women who had cervical cancer.

Key word: cervical cancer, prevalence, risk factor, abortion, pregnancy

ГАРЧИГ

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

БҮЛЭГ 1. УДИРТГАЛ

1.1. Судалгааны ажлын үндэслэл	8
1.2. Судалгааны ажлын зорилго, зорилт	9
1.3. Судалгааны ажлын шинэлэг тал	10
1.4. Судалгааны ажлын практик ач холбогдол	10
1.5. Судалгааны ажлын бүтэц	10
1.6. Судалгааны ажлын үр дүнг хэлэлцүүлсэн байдал	11
1.7. Судалгааны ажлыг хэвлүүлсэн байдал	11
1.8. Судалгааны ёс зүйн асуудлууд	12

БҮЛЭГ 2. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ

2.1. Умайн хүзүүний өмөн, эрт илрүүлгийн тухай	13
2.2. Умайн хүзүүний өмөнгийн эрсдэлт хүчин зүйлс, тархалт	19
2.3. Умайн хүзүүний өмөнгийн оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт	25

БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН БА АРГА ЗҮЙ

3.1. Судалгааны загвар	27
3.2. Судалгааны хүрээ ба түүвэр	27
3.3. Судалгааны ажлын хэрэглэгдэхүүн	28
3.4. Судалгааны материал цуглуулсан аргууд	29
3.5. Статистик боловсруулалт	32

БҮЛЭГ 4. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН

Судалгаанд оролцогчдын ерөнхий шинж байдал	33
--	----

4.1. УХӨ-ийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт	35
- Өмөнгийн урьдал эмгэгийн тархалт	36
- Тамхитаталт	38
- Олон удаа жирэмслэх	39
- 18 наснаас өмнө эрт төрөх	40
- Олон удаа үр хөндүүлэх	40
- Бэлгийн харьцаанд эрт насандаа орох	41
- Жирэмслэхээс сэргийлэх дааврын бэлдмэл хэрэглэх	42
- БЗХӨ-ий тархалт	43
- Регрессийн шинжилгээ	44
- Бэлгийн хамтрагчийн тоо	44
- Эсийн шинжилгээнд хамрагдаж байгаагүй байдал	45
- УХӨ-г эрт илрүүлэх шинжилгээний дүн	45
- 5%-ийн цууны хүчлийн сорилын дүн	46
- Эсийн шинжилгээний дүн	47
- УХӨ-ийн урьдал эмгэгтэй эмэгтэйчүүдийн дунд эрсдэлт хүчин зүйлийн тархалт	49
БҮЛЭГ 5. ХЭЛЦЭМЖ	50
СУДАЛГААНЫ АЖЛЫН ДҮГНЭЛТ	61
НОМ ЗҮЙ	
ТАЛАРХАЛ	
ХАВСРАЛТ	